



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтэс

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Хэлтсийн дарга

Тэргүүн түшмэл, АА-3

Ажлын цаг:

Ажлын байрны албан ёсны байршил:

Ажлын өдрийн 8 цаг

Чингэлтэй дүүрэг, Ж.Самбуугийн гудамж, Засгийн газрын XI байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хэвийн

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнд эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар шийтгэх буюу хүний нэр төрийг доромжлон харьцахаас урьдчилан сэргийлэх, хяналт тавихад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, хэлтсийн хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх, дотоод зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэх, санал оруулах, туслах чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд нэгжийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, гүйцэтгэлийн үр дүнг Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

- 1.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгжийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх, дотоод зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэх, санал оруулах, хэрэгжүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах, хяналт тавих;
- 2.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны судалгаа, дүн шинжилгээ, хяналт шинжилгээ, үнэлгээг төлөвлөх, нэгдсэн арга зүйгээр хангах, хяналт тавих, тайлагнах;
- 3.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангах, хяналт тавих, үр дүнг танилцуулах;
- 4.Нэгжийн гадаад, дотоод хамтын ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалтыг хэрэгжүүлэх, тайлагнах.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Байгууллагын стратеги төлөвлөгөөтэй уялдуулан нэгжийн төлөвлөгөөг боловсруулж, танилцуулах;	Гүйцэтгэлийн төлөвлөгөө нь байгууллагын стратеги, гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдсан байна.	Г, Х
	2.Нэгжийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавих, албан хаагчдын ажил үүргийг тэнцвэртэй, оновчтой хуваарилах, гүйцэтгэлд хяналт тавих, дүгнэх, зөвлөн туслах, чиглүүлэх, арга зүйн удирдлагаар хангах;	Албан хаагчдын гүйцэтгэлийн зөрүүг арилгах арга хэмжээ авсан байна.	Г, Х, Ш
	3.Нэгжийн албан хаагчдын цалин хөлс, сургалт, нийгмийн баталгааг хангах, ажлын хариуцлага тооцуулах асуудлаар санал боловсруулах, танилцуулах;	Холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх санал танилцуулж, шийдвэрлүүлсэн байна.	Г, Х
	4.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмж, саналын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, цаашид авах арга хэмжээний саналаа танилцуулж, шийдвэрлүүлэх;	Үндэслэл бүхий санал гаргаж, шийдвэрлүүлсэн байна.	Г
	5.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний хууль тогтоомж, төрийн байгууллагын шийдвэрийн төсөл эрүү шүүлтээс урьдчилан	Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн хууль тогтоомж, төрийн	Г, Х, Ш



	сэргийлэх зарчимд нийцэж байгаа эсэх талаар санал, зөвлөмж гаргах эрхийг хэрэгжүүлэхэд туслах чиглэлээр нэгжийн үйл ажиллагааг зохион байгуулах, хянах, тайлагнах;	байгууллагын шийдвэрийн төсөл эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх зарчимд нийцэж байгаа эсэх талаар санал, зөвлөмж гаргах эрхээ хэрэгжүүлэхэд тусалсан байна.	
	6.Хууль тогтоомж, тогтоол, шийдвэр төлөвлөгөөний биелэлт, тайлан мэдээг нэгтгэн гаргах, танилцуулах, хяналт тавих;	Төлөвлөгөөний биелэлт, тайлан мэдээг хугацаанд нь үнэн зөв гаргасан байна.	Г, Х
	7.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг хянах, танилцуулах;	Үйл ажиллагааны хэрэгжилт хангагдсан байна.	Г, Х
	8.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгжийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх, дотоод зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэх, санал оруулах, хэрэгжүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах, хяналт тавих;	Нэгжийн үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөлтийг хийж эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнд хянуулж, батлуулан, гүйцэтгэлд хяналт тавьж, дотоод үйл ажиллагаа, хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх санал оруулж, шийдвэрлүүлэн гүйцэтгэлийг тайлагнасан байна.	Г, Х, Ш
	9.Албан хаагчдын ёс зүйн дүрэм болон хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтийг хангуулах, Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааг дэмжин ажиллах;	Холбогдох арга хэмжээ авсан байна.	Х
	10.Нэгжид хуваарилагдсан баримт бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавих, албан хэргийг стандарт, зааврын дагуу хөтлөх, архивын нэгж бүрдүүлэх ажлыг зохион байгуулах.	Өргөдөл, гомдол, албан бичгийг хугацаанд нь хуулийн дагуу, үндэслэлтэй шийдвэрлэсэн байна	Х
2 дугаар зорилтын хүрээнд	1.Аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй бүх газарт эрүү шүүлт гарч болзошгүй тогтолцооны шалтгаан нөхцөлийг судлах, хяналт шинжилгээний ажлыг чиглүүлэх, зохион байгуулалтаар хангах, хяналт тавих, тайлагнах;	Хяналт шинжилгээг тогтмол явуулж, нэгжийг зохион байгуулалтаар хангаж, хяналт тавин, үр дүнг тооцож, тайлагнаж, ажилласан байна.	Г, Х



	2.Хяналт шинжилгээ хийх ажлын удирдамж, ажил үүргийн хуваарь, санал асуулгын боловсруулалтыг хянах, гүйцэтгэлд хяналт тавих, тайлагнах;	Хяналт шинжилгээний бэлтгэл ажил бүрэн хангагдсан байна.	X
	3.Хяналт шинжилгээний илтгэх хуудсыг хянах, гаргасан саналыг үндэслэн шийдвэрлэлтийн талаарх саналаа Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнд танилцуулах;	Хяналт шинжилгээг чанартай, хугацаанд нь гүйцэтгэж, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмж, санал гаргах төслийг бэлдэн, танилцуулж, шийдвэрлүүлсэн байна.	X, Ш
	4.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний хяналт шинжилгээ, төлөөлөн нэхэмжлэл, хууль зүйн зөвлөгөө, зөвлөмж, саналын тайлан, бүртгэлийг хуулийн дагуу зохион байгуулж, хяналт тавин, тайлагнах.	Нэгжийн бүртгэл, мэдээллийн сан хангагдсан байна.	X
3 дугаар зорилтын хүрээнд	1.Олон нийтэд эрүү шүүлтийн хор аюулыг тайлбарлан таниулах, эрүү шүүлтээс ангид байх эрхийг төрийн албан тушаалтан, иргэдэд сурталчлах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр явуулах ажлыг зохион байгуулж, хяналт тавих, тайлагнах;	Эрүү шүүлтийн хор аюулыг олон нийтэд сурталчлах ажил тогтмолжсон байна.	Г, X
	2.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар судалгаа хийх, ном, сургалт, сурталчилгааны хэрэглэгдэхүүн, сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах зэрэг ажлыг эрхлэн явуулах, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг оролцуулах, хяналт шинжилгээ хийх арга зүй боловсруулах ажлыг арга зүйгээр хангах, хяналт тавих, тайлагнах;	Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ном, сургалт, сурталчилгааны хэрэглэгдэхүүн, сургалтын хөтөлбөр, гарын авлага, хяналт шинжилгээ хийх арга зүйн хэрэглэгдэхүүнтэй болсон байна.	Г, X
	3.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, гарч болзошгүй үр дагаврын талаар сургалт, арга зүйн ажлыг төлөвлөх, нэгдсэн удирдлагаар хангах, хяналт тавих, тайлагнах;	Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх талаарх олон нийтийн ойлголт, хандлага нэмэгдсэн байна.	Г, X
	4.Хариуцсан чиг үүргийн хүрээнд хууль тогтоомж, шийдвэрийн төсөлд өгөх саналыг боловсруулж	Чиг үүргийн хүрээнд хууль тогтоомж, шийдвэрийн төсөлд	Г




	эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнд танилцуулах;	өгөх саналыг боловсруулж эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнд танилцуулсан байна.	
	5.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмж, саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдэд цаг тухайд нь хүргүүлэх ажилд хяналт тавих, хариуг хугацаанд авах, биелэлтийг тооцон, санал боловсруулах, танилцуулах.	Олон улсын гэрээ, конвенц, дотоодын хууль тогтоомж, хүний эрхийн зарчимд нийцсэн үндэслэл бүхий санал гаргаж, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласан байна.	Г, Х, Ш
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний өгсөн чиглэлийн дагуу нэгжийн гадаад, дотоод хамтын ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалтыг хэрэгжүүлэх, тайлагнах;	Нэгжийн дотоод, гадаад хамтын ажиллагааны төлөвлөлтийг боловсруулах ажлыг зохион байгуулж, нэгтгэн, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан гишүүнээр батлуулж, гүйцэтгэлд хяналт тавьж, тайлагнасан байна.	Г, Х
	2.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг эрхэлсэн гишүүний эзгүйд түүний эрх олгосноор дотоод, гадаадад төлөөлөх, ашгийн төлөө бус хуулийн этгээд болон бусад байгууллагатай хамтран ажиллах чиглэлээр удирдлага, зохион байгуулалтаар хангах, хяналт тавих, тайлагнах;	Нэгжийн дотоод, гадаад хамтын ажиллагаа өргөжсөн байна.	Г, Х
	3.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн хуулиар олгосон бүрэн эрхээ хэрэгжүүлэх, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дотоод, гадаад харилцаанд төлөөлөх үеийн аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулах, хариуцах, тайлагнах.	Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны бүрэн, тасралтгүй, үр нөлөөтэй, хараат бус байдал хангагдсан байна.	Г, Х, Ш

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.
Мэргэжил	- бизнес, удирдлага, эрх зүй /042101, 041305, 041307/;



	<ul style="list-style-type: none"> - нийгмийн болон зан үйлийн шинжлэх ухаан /031203, 031301, 031402, 031404/; - иргэн ба өмч хамгаалал /103201, 103203, 103204, 103207/; - эрүүл мэнд, нийгмийн хамгаалал /091220, 092301/; - нийгмийн ухааны боловсрол /011414/. 	
Мэргэшил	<ul style="list-style-type: none"> - Тэргүүн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх; - Хүний эрхийн чиглэлээр мэргэшүүлэх сургалтад хамрагдсан бол давуу тал болно. 	
Туршлага	Төрийн албанд 16-аас доошгүй жил, үүнээс эрхэлсэн түшмэлийн албан тушаалд 8-аас доошгүй жил ажилласан байх.	
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> - эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний өгсөн чиглэлийн дагуу нэгжийн үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулж, гүйцэтгэлийг дүгнэх; - албан хаагчийн санал, бодлыг нь сонсох, эргэх холбоотой байх, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - албан хаагчийн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, үр дүнг сайжруулахад зөвлөх, чиглүүлэх; - нэгжийн албан хаагчдад ажил үүргийг тэнцвэртэй, хуваарилах, ачааллыг жигдрүүлэх; - нэгжийн албан хаагчийн мэдлэг, ур чадвар, туршлага, авьяасыг бүрэн дайчлах; - нэгжийн үйл ажиллагааны явцад үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах; - бусад.
	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - эрүү шүүлт гарч болзошгүй тогтолцооны шалтгаан, нөхцөлийг судлах зорилгоор тогтмол хяналт шинжилгээ үнэлгээ хийх, санал, зөвлөмж өгөх; - судалгааны мэдээлэлд тулгуурлан чиг үүргийн болон системийн шинжилгээ хийх; - судалгааны үр дүн, шийдлийн хувилбаруудын шууд ба шууд бус үр дагаврыг харьцуулан үнэлэх; - бусад.
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдвэрийг шуурхай гаргах; - хариуцсан чиг үүргийн хүрээнд хууль тогтоомж, шийдвэрийн төсөлд өгөх саналыг боловсруулж эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнд танилцуулах; - албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд асуудлыг хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - хариуцсан чиг үүргийнхээ хүрээнд гаргасан шийдвэрийнхээ үр дагаврыг хариуцах; - эрүү шүүлт гарч болзошгүй тогтолцооны шалтгаан, нөхцөлийг судалж, асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж, түүний эерэг, сөрөг үр дагаврын талаар эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнд танилцуулж, шийдвэрлүүлэх; - бусад.
	Манлайлах	<ul style="list-style-type: none"> - ёс зүйгээр бусдыг манлайлан үлгэрлэх;



		<ul style="list-style-type: none"> - нэгжийн үйл ажиллагаанд шинэлэг санаа, үйлчилгээг нэвтрүүлэх, албан хаагчдын шинэ санаачилга, бүтээлч үйл хандлагыг дэмжих; - хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалтын хувьд нэгжийн хамт олныг үлгэрлэх; - байгууллагын болон нэгжийн үйл ажиллагааны зорилго, зорилтыг бусдад тайлбарлан таниулах, хэрэгжүүлэх; - нэгжийн стратеги зорилтыг тодорхойлохдоо хамт олны саналыг сонсох, тусгах, өөрчлөлтийг хийхдээ урьдчилан тооцоолж, манлайлан удирдах; - бусад.
	Бусад	<ul style="list-style-type: none"> - үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэх; - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах; - багаар ажиллах, багийн амжилтыг үнэлэх, дэмжих, бусдад таниулах; - хүний эрхийн чиглэлээр мэргэшсэн, судалгаа, шинжилгээний ажлын туршлагатай байх; - харилцааны орчин үеийн арга хэлбэрийг ашиглах; - кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх; - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах, цахим орчинд ажиллах чадвартай байх; - хүний эрхийн хандлага, мэдрэмжтэй байх; - иргэд, байгууллагатай эелдэг, соёлтой, хүндэтгэлтэй харилцах; - мэдээллийг шуурхай хүргэх, мэдээлэл солилцох соёлыг төлөвшүүлэх; - нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх; - эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх гишүүний хэрэгжүүлэх чиг үүргийн онцлогийн дагуу нэгжийн шуурхай, бэлэн байдлыг хангах; - захирах, захирагдах ёсыг баримтлах; - албан үүрэгтэй нь холбогдож мэдсэн, эсхүл өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээллийг задруулахгүй байх.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:


Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн.

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

- хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах референт-1
- сургалт, сурталчилгаа хариуцсан ахлах референт-1
- судалгаа, дүн шинжилгээ хариуцсан референт-1
- сургалт хариуцсан референт-1
- сурталчилгаа хариуцсан референт-1

Бусад харилцах субъект

- Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллага, бусад төрийн байгууллагын холбогдох албан тушаалтан, албан хаагч;



<ul style="list-style-type: none"> - тогтоол шийдвэр, бүртгэл, мэдээлэл хариуцсан ахлах мэргэжилтэн-1 - хэвлэл, мэдээлэл хариуцсан ахлах мэргэжилтэн-1 - хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн-1 - мэргэжилтэн-1 <p>Нийт: 9</p>	<ul style="list-style-type: none"> - төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөрийн зохицуулагч; - иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн байгууллага.
--	---

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

<p><u>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</u></p>	<p><u>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</u></p>
<p><u>Албан тушаал:</u></p> <p>МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ГИШҮҮН</p> <p style="text-align: right;">Я.ЦЭЛМЭН</p> <p>20<u>22</u> оны <u>07</u> дугаар сарын <u>21</u>-ны өдөр</p>	<p><u>Байгууллагын нэр:</u></p> <p>ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ</p> <p><u>Шийдвэрийн огноо:</u> 22 07 07</p> <p><u>Дугаар:</u> 541</p>

Албан тушаалын тодорхойлолт баталсан:

<p><u>Байгууллагын нэр:</u></p> <p>МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС</p> <p><u>Шийдвэрийн огноо:</u> 2022.07.21</p> <p><u>Дугаар:</u> А/56</p> <p>(тамга/тэмдэг)</p> <p style="text-align: center;">ДАРГА Ж.ХУНАН</p> <p style="text-align: center;">20<u>22</u> оны <u>07</u> дугаар сарын <u>21</u>-ны өдөр</p>

